



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 125

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 1 дүгээр баг, 7 дугаар хэсэгт байрлах хавсралтад заасан орон сууцыг төрийн өмчид хүлээн авч, Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албанд эзэмшүүлж үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

2.Замын-Үүд чөлөөт бүсийн захирагч А.Энхзулд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх,

2.3.Энэ шийдвэрийг Улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлж хавсралтад заасан орон сууц төрийн өмч болохыг мэдэгдэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001220

Төрийн өмчийн бодлого-зохицуулалтын газрын
2022 оны 04 дүгээр сарын өдрийн
.....дугаар тогтоолын хавсралт

**Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны үндсэн хөрөнгөд
бүртгэх үл хөдлөх хөрөнгө**

д/д	Үндсэн хөрөнгийн байршил нэр	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ /бүртгэх үнэ/ (төгрөг)
1	Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 1-р баг, 7 дугаар хэсэгт байрлах 40 айлын орон сууцны 2-504 тоот 2 өрөө орон сууц.	2009	м.кв	67.06	65,500,000.00
2	Нийт дүн				65,500,000.00 Жаран таван сая таван зуун мянга